


Захирлын 2021 оны ... дугаар
сарын 06...-ны өдрийн ... дугаар
тушаалын ... дүгээр хавсралт




МУИС-ИЙН ХАРЬЯА БАЙГАЛЬ-ЭХ ЛИЦЕЙ АХЛАХ СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

1. МУИС-ийн харьяа Байгаль-Эх лицей ахлах сургуулийн байгалийн ухааны гүнзгийрүүлсэн сургалттай 10 дугаар ангид нийслэл хот болон хөдөө орон нутгаас 2021-2022 оны хичээлийн жилд суралцагч элсүүлэхэд энэхүү журмыг баримтална.
2. Байгаль-Эх лицей ахлах сургуульд элсэхээр бүртгүүлэгч, элсэгч болон элсэлтийн комиссын үйл ажиллагааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.
3. Байгаль-Эх лицей ахлах сургуульд элсэхээр хүсэлт гаргасан суралцагчийг "бүртгүүлэгч", зохих болзол хангаж элсэлтийн хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчийг "элсэгч", элсэлтийн үйл ажиллагааг нэгдсэн байдлаар зохион байгуулахаар томилогдсон комиссыг "элсэлтийн комисс", "элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахад оролцох ажилтныг "комиссын гишүүн" гэнэ.
4. Байгаль-Эх лицей ахлах сургуульд суралцагч элсүүлэх ажлыг МУИС-ийн захирлын тушаалаар томилсон комисс зохион байгуулна.
5. Бүртгүүлэгч бүртгүүлэхээс өмнө энэхүү журамтай танилцах үүрэгтэй.
6. Энэхүү журам болон нэмэлт мэдээллийг <http://www.num.edu.mn>, <http://eecbehs.num.edu.mn> цахим хуудсанд байрлуулна.
7. Энэхүү журмаар зохицуулагдахгүй асуудал гарвал МУИС-ийн захирлын тушаалаар байгуулсан элсэлтийн комисс шийдвэрлэнэ.
8. Элсэлтийн шалгалтын хэлбэр, асуулт даалгавар, сэдэв боловсруулах, шалгалтын хугацаа ба үнэлгээний шалгуур тогтоох, нууцлал хадгалах зэрэг асуудлыг элсэлтийн комиссын дарга, нарийн бичгийн дарга, комиссын гишүүд хариуцна.
9. Тус сургуульд элсэхийг хүссэн, 9 дүгээр анги төгсөж байгаа суралцагчдыг бүртгэнэ.
10. Нийт бүртгүүлэгчдээс математик, физик, хими, биологи нэгдсэн шалгалтыг тестээр авна. Онооны жагсаалтыг математик, математик физик, математик хими, математик биологи гэж гарган, гүнзгийрүүлэн судлах чиглэлийн бүлэг тус бүрээр зохих

хяналтын тоонд багтааж элсүүлнэ.

11. Элсэх болзол хангаж, хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчдийг заасан хугацаанд сургалтын төлбөрийн 50 хувь 1750000 (Нэг сая долоон зуун тавь мянга) төгрөгийг сургуулийн ХААН банк дахь 5041126984 тоот дансанд тушаасан баримтаар бүртгэж, ангийн суудал, элсэх эрхээ баталгаажуулна.



12. Зарласан хугацаанд ирж бүртгүүлээгүй элсэгчийг тус сургуульд элсэхээс татгалзсан гэж үзэн, дараа өдрийн 10:00 цагаар тасалбар болгон онооны дарааллаар дараагийн шалгуулагчид элсэх эрхийг шилжүүлнэ.

13. 2021-2022 оны хичээлийн жилд элсэх эрхээ баталгаажуулсан элсэгчид 2021 оны 08 дугаар сарын 20-ноос 31-ний өдрийн хооронд дараах материалыг бүрдүүлж, бүртгүүлнэ. Үүнд:

- Төрсний гэрчилгээний хуулбар
- Суурь боловсролын гэрчилгээ
- Хувийн хэрэг /шилжүүлсэн байх/
- Сургалтын төлбөрийн үлдэгдэл 50 хувь 1750000 (Нэг сая долоон зуун тавин мянга) төгрөгийг дээрх дансанд төлсөн баримт.

14. Тухайн элсэгчийн сонгосон бүлгээс өөр бүлэгт шилжүүлэн элсүүлэхгүй ба элсэлтийн эрхийн бичгийг бусдад шилжүүлэхийг хориглоно.